



“ГУТАЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Улаанбаатар-17043
ХУД, 2-р хороо
Чингисийн өргөн чөлөө
“Гутал” ХК

Утас: 976 -11 - 342637
Факс: 976 -11- 343267
Вэб сайт: www.gutalco.mn
Э-шуудан: gutal.company@gmail.com

Огноо 2015.10.09

Дугаар 0.1

Улаанбаатар хот

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.2 дахь заалт, “Гутал” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.34 дэх заалт, Компанийн Засаглалын Кодексийн 5.2.5 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр Гутал ХК-д ирүүлсэн “Компанийн дотоод асуудалд хорооны зүгээс оролцохгүй” гэсэн агуулга бүхий албан бичиг, 2015 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн United Partners ХХН, 2015 оны 10 дугаар сарын 5-ны өдрийн Адвокатконсалтинг ХХН-өөс тус тус ирүүлсэн “Хөндлөнгөөс аливаа гуравдагч этгээд оролцох боломжгүй, дотооддоо шийдвэрлэж зохицуулах нь зүйтэй” гэсэн агуулга бүхий хариу, 2015 оны 10 дугаар сарын 9-ний өдрийн Гутал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэл, компанийн өнөөгийн санхүүгийн байдал, хамтран ажилладаг байгууллагуудын албан шаардлага, итгэлцэл зэрэг нөхцөл байдлыг үндэслэн

ТОГТООХ нь:

1. Гутал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар О.Буяннэмэхийг сонгосугай.
2. Гутал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод байгуулах, хороодын гишүүдийг сонгох асуудлыг зохион байгуулж, дараагийн хуралд хэлэлцүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад үүрэг болгосугай.
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмыг хавсралт ёсоор баталсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД:

Х.АЛТАЙ /Эчнээ саналаар/ - 804

Б.БАТТӨР /Эчнээ саналаар/

Б.БАТХИШИГ /Эчнээ саналаар/

Б.БҮҮВЭЙ

О.БУЯННЭМЭХ

Т.ДАРИМА

Ч.ДОЛГОРМАА





“ГУТАЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Улаанбаатар-17043
ХУД, 2-р хороо
Чингисийн өргөн чөлөө
“Гутал” ХК

Утас: 976 -11 - 342637
Факс: 976 -11- 343267
Вэб сайт: www.gutalco.mn
Э-шуудан: gutal.company@gmail.com

Огноо 2015.10.09


Дугаар 02

Улаанбаатар хот

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.2 дахь заалт, “Гутал” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.34 дэх заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр Гутал ХК-д ирүүлсэн “Компанийн дотоод асуудалд хорооны зүгээс оролцохгүй” гэсэн агуулга бүхий албан бичиг, 2015 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн United Partners ХХН, 2015 оны 10 дугаар сарын 5-ны өдрийн Адвокатконсалтинг ХХН-өөс тус тус ирүүлсэн “Хөндлөнгөөс аливаа гуравдагч этгээд оролцох боломжгүй, дотооддоо шийдвэрлэж зохицуулах нь зүйтэй” гэсэн агуулга бүхий хариу, 2015 оны 10 дугаар сарын 9-ний өдрийн Гутал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэл, компанийн өнөөгийн санхүүгийн байдал, хамтран ажилладаг байгууллагуудын албан шаардлага, итгэлцэл зэрэг нөхцөл байдлыг үндэслэн

ТОГТООХ нь:

1. Төлөөлөн удирдах зөвлөлөөс ерөнхий захирал Ц.Төмөртэй 2014 оны 7 дугаар сарын 4-ний өдөр байгуулсан гэрээний цалин, урамшуулал, хангамжийн нөхцлийг хэвээр, бусад нөхцөлийг хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж, сунгасугай.
2. Ерөнхий захирал Ц.Төмөрт компанийн санхүүгийн байдал, үүсээд байгаа асуудлыг анхаарч, шуурхай арга хэмжээ авч ажиллахыг үүрэг болгосугай.

ДАРГА  О.БУЯННЭМЭХ





“ГУТАЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Улаанбаатар-17043
ХУД, 2-р хороо
Чингисийн өргөн чөлөө
“Гутал” ХК

Утас: 976 -11 - 342637
Факс: 976 -11- 343267
Вэб сайт: www.gutalco.mn
Э-шуудан: gutal.company@gmail.com

Огноо 2015.10.09

Дугаар 03

Улаанбаатар хот

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.5 дахь заалт, “Гутал” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.39 дэх заалт, 2015 оны 10 дугаар сарын 9-ний өдрийн Гутал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. ТУЗ-ийн хараат бус гишүүн Х.Алтайгийн 2015 оны 9дүгээр сарын 28-ны өдрийн “хараат бус гишүүнээс чөлөөлөгдөх тухай” өргөдлийг Төлөөлөн удирдах зөвлөл хүлээн авч, Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр уламжилсугай.
2. Хуульд заасан журмын дагуу ТУЗ-ийн хараат бус гишүүнийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаас нөхөн томилтол түр томилогдох этгээдийг ТУЗ-ийн дараагийн хурлаар хэлэлцэхээр шийдвэрлэсүгэй.
3. ТУЗ-ийн хараат бус гишүүнд түр томилогдох нэр дэвшигчдийн танилцуулгыг бэлтгэн дараагийн хуралаар хэлэлцүүлэх бэлтгэлийг хангах ажлыг зохион байгуулахыг ТУЗ-н даргад үүрэг болгосугай.

ДАРГА  О.БУЯННЭМЭХ





“ГУТАЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Улаанбаатар-17043
ХУД, 2-р хороо
Чингисийн өргөн чөлөө
“Гутал” ХК

Утас: 976 - 11 - 342637
Факс: 976 - 11 - 343267
Вэб сайт: www.gutalco.mn
Э-шуудан: gutal.company@gmail.com


Огноо 2015.10.09

Дугаар 04

Улаанбаатар хот

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.2 дахь заалт, 2015 оны 10 дугаар сарын 9-ний өдрийн Гутал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Номин реалтор” ХХК-ийн түрээсийн зүйлд оруулсан хөрөнгө оруулалтыг баталгаажуулах үүргийн дагуу санхүүгийн үнэлгээний аж ахуй нэгж, байгууллагыг судлаж, Төлөөлөн удирдах зөвлөлийн дараагийн хуралд танилцуулахыг ерөнхий захирал /Ц.Төмөр/-д үүрэг болгосугай.

ДАРГА  О.БУЯННЭМЭХ

